



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 09 өдөр

Дугаар А/411

Хэрлэн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1, 60.1.21, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.1.1, 8.1.3 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын Волейболын холбооны Хэнтий аймаг дахь салбар зөвлөлөөс ирүүлсэн хүсэлтийн дагуу Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах Волейболын тэмцээнд оролцоход шаардагдах зардалд 2,500,000 (хоёр сая таван зуун мянган зуун) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн байгууллага, иргэдээс тавьсан санал хүсэлтийг шийдвэрлэх зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010931